

# “ГЛОБАЛ МОНГОЛИА ХОЛДИНГС” ХК ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2024 оны 03 дугаар  
сарын 15-ны өдөр

№ 24-06

Улаанбаатар  
хот

## Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал зарлах тухай

Компанийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.4 дэх хэсэг, 60 дугаар зүйл, 64 дүгээр зүйлийн 64.1, 64.2, 64.4 дэх хэсэг, 65 дугаар зүйл, 76 дугаар зүйлийн 76.1.2 дахь заалт, 76.1.3 дахь заалт, Санхүүгийн Зохицуулах Хорооны 2018 оны 12 сарын 14-ний өдрийн 377 дугаар тогтоолоор батлагдсан “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам”, “Глобал Монголиа Холдингс” ХК (цаашид “Компани” гэх)-ийн дүрмийн холбогдох хэсгийг тус тус үндэслэн **ТОГТООХ нь:**

1. “Глобал Монголиа Холдингс” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2024 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн 11:00 цагт Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 2-р хороо, Соёмбо тауэр, 21 давхар, 211 тоот хаягт зарлан хуралдуулсугай.
2. Хувьцаа эзэмшигчдийн хурлыг зарлах тухай мэдэгдлийг 2024 оны 03 дугаар сарын 18-ны өдрийн дотор Монголын Хөрөнгийн Бирж, Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв, Санхүүгийн Зохицуулах Хороонд тус тус хүргүүлсүгэй.
3. Хурал хуралдуулах тухай зар мэдээг Монголын Хөрөнгийн Биржийн цахим хуудас, өдөр тутмын сонин болон бусад хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан 2024 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн дотор нийтэд мэдээлж, уг зарын давталтыг 2024 оны 04 дүгээр сарын 04-ний өдөр анх зарласан хэлбэрээр дахин нийтэд мэдээлсүгэй.
4. Хуралд оролцох эрхтэй Хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2024 оны 04 дүгээр сарын 05-ны өдрөөр тогтоосугай.
5. Хурлаар хэлэлцэх асуудлын жагсаалт, гарах шийдвэрийн төсөл; саналын хуудас зэрэг бусад холбоотой баримт бичгийг 2024 оны 03 дугаар сарын 21-ний өдөрт багтаан үнэт цаасны брокер, дилерийн компанид цахим хэлбэрээр болон шуудангаар хүргүүлсүгэй.
6. Хурлын даргаар Глобал Монголиа Холдингс ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дарга Ким Ки Хюун-г томилсугай.
7. Хурал зохион байгуулах комиссыг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай. Үүнд
  - 7.1. Хурал зохион байгуулах комиссын дарга:
    - М.Лхамсүрэн
  - 7.2. Хурал зохион байгуулах комиссын гишүүд:
    - Г.Хажидмаа
    - Т.Отгон
8. Хурлаар хэлэлцэх асуудлын жагсаалтыг Хавсралт №1-ийн дагуу, хурлын нийтэд хүргэх зарыг Хавсралт №2-ын дагуу, хувьцаа эзэмшигчдээс санал авах хуудсыг Хавсралт №3-ын дагуу, хувьцаа эзэмшигчдийн танилцаж болох баримт бичгийн жагсаалтыг Хавсралт №4-ийн дагуу, хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас гарах тогтоолын төслийг Хавсралт №5-ын дагуу тус тус баталсугай.
9. Хувьцаа эзэмшигчдийн хуралтай холбоотойгоор саналын хуудас хүлээн авах сүүлчийн хугацаа нь 2024 оны 4 дүгээр сарын 24-ний өдрийн 18 цаг 00 минут хүртэл байхаар тогтоосугай.

10. Хурлын тооллогын комиссыг дараах бүрэлдэхүүнтэй ажиллуулахыг зөвшөөрсүгэй.
- 10.1. Хурлын тооллогын комиссын дарга:
    - Г.Хажидмаа
  - 10.2. Хурлын тооллогын комиссын гишүүд:
    - Ү.Ананд
    - М.Энхмарал
11. Энэхүү шийдвэрийн хэрэгжилтэд хяналт тавьж, холбогдох мэдээлэл, баримт бичгийг хүргүүлэх, бүртгүүлэх ажлыг хийж гүйцэтгэхийг Хурлын даргад даалгасугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА ..... КИМ КИ ХЮУН





УЛААНБААТАР ХОТ  
“Глобал Монголиа Холдингс” ХК  
Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны  
03 дугаар сарын 15-ны өдрийн 24-06  
тоот тогтоолын Хавсралт №1



**Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар  
хэлэлцэх асуудлын жагсаалт**

Д/д	Хэлэлцэх асуудал	Танилцуулах
1.	Компанийн 2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэн батлах	Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дарга Ким Ки Хюун
2.	Компани нэмж хувьцаа гаргах, нэмж гаргаж буй хувьцааг тэргүүн ээлжинд худалдан авах эрхийг хэрэгжүүлэх эсэхийг шийдвэрлэх, дүрмийн шинэчилсэн найруулга батлах тухай	Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дарга Ким Ки Хюун
3.	ТУЗ-аас ногдол ашиг хуваарилахгүй гэж шийдвэрлэсэн үндэслэлээ тайлагнах	Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дарга Ким Ки Хюун
4.	Бусад	Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дарга Ким Ки Хюун

“Глобал Монголиа Холдингс” ХК  
Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны  
03 дугаар сарын 15-ны өдрийн 24-06  
тоот тогтоолын Хавсралт №2



## Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын зар

### “Глобал Монголиа Холдингс” ХК –ийн хувьцаа эзэмшигчдийн анхааралд

**Компанийн нэр:** “Глобал Монголиа Холдингс” ХК

**Хаяг:** Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, Сүхбаатар дүүрэг, 2-р хороо, Соёмбо тауэр, 21 давхар, 211 тоот хаягт

**Хурал болох огноо, байршил :** 2024.04.25-ны өдрийн 11:00 цагт компанийн хурлын танхимд

**Хурал зохион байгуулах хэлбэр:** Хосолсон /танхим, саналын хуудсаар/

**Хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдөр:** 2024 оны 04 дүгээр сарын 05-ны өдөр

**Хурлаар хэлэлцэх асуудлууд:**

1. Компанийн 2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэн батлах
2. Компани нэмж хувьцаа гаргах, нэмж гаргаж буй хувьцааг тэргүүн ээлжинд худалдан авах эрхийг хэрэгжүүлэх эсэхийг шийдвэрлэх, дүрмийн шинэчилсэн найруулга батлах тухай
3. ТУЗ-аас ногдол ашиг хуваарилахгүй гэж шийдвэрлэсэн үндэслэлээ тайлагнах
4. Бусад

**Хувьцаа эзэмшигчдийн танилцах баримт бичгийн жагсаалт:**

1. “Глобал Монголиа Холдингс” ХК-ийн 2023 оны жилийн үйл ажиллагааны тайлан;
2. “Глобал Монголиа Холдингс” ХК-ийн 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан;
3. “Глобал Монголиа Холдингс” ХК-ийн 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг баталгаажуулсан аудитын дүгнэлт;
4. “Глобал Монголиа Холдингс” ХК-ийн хувьцааны сүүлийн 6 сарын болон сүүлийн 30 хоногийн арилжааны жигнэсэн дундаж ханшийн мэдээлэл;
5. Ногдол ашиг хуваарилах эсэх тухай ТУЗ-ийн хурлын 2024 оны 02 дугаар сарын 19-ний өдрийн 24/01 тоот тогтоол;
6. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцэх асуудалд санал өгөх Саналын хуудасны загварууд;
7. Бусад

**Санал өгөх хэлбэр:**

**Биечлэн:** Хувьцаа эзэмшигч, та хуралд биечлэн хүрэлцэн ирж саналаа өгөх боломжтой.

**Саналын хуудсаар:** Хуралд биечлэн оролцох боломжгүй бол хувьцаа эзэмшигч та саналаа урьдчилан өгөх боломжтой бөгөөд саналын хуудсыг бөглөн Компанийн төв байранд эсхүл өөрийн үйлчлүүлдэг үнэт цаасны компаниар дамжуулан өгч болно.

Саналын хуудсыг хүлээн авах сүүлчийн хугацаа нь 2024 оны 4 дүгээр сарын 24-ны өдрийн 18 цаг 00 минут хүртэл байна.

Хувьцаа эзэмшигч та 2024 оны 04 дүгээр сарын 08-ны өдрөөс хойш <https://gmholdings.mn/> цахим хуудсанд хандан хурлын материалтай танилцаж, санал өгөх зааврыг авах боломжтой.

## Холбоо барих

Асууж тодруулах зүйл байвал ажлын өдрүүдэд 10:00-17:00 цагийн хооронд дараах газрууд руу хандан заавар, зөвлөмж авна уу. Үүнд:

- ✚ Компанийн лавлах дугаар: 7000-2062
- ✚ Компанийн цахим шуудан: [lkhamsurem@kepartners.mn](mailto:lkhamsurem@kepartners.mn), [khajidmaa@kepartners.mn](mailto:khajidmaa@kepartners.mn), [otgon@kepartners.mn](mailto:otgon@kepartners.mn)
- ✚ Компанийн байр: Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 2-р хороо, Соёмбо тауэр, 21 давхар, 211 тоот
- ✚ Өөрийн үйлчлүүлдэг үнэт цаасны компани



## ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИЙН ЭЭЛЖИТ ХУРАЛД САНАЛ АВАХ ХУУДАС

Хувьцаа эзэмшигчийн овог ..... нэр .....

Хувьцаа эзэмшигчийн регистрийн дугаар: .....

Санал өгөх хувьцааны тоо: .....

Глобал Монголия Холдингс ХК-ын Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2024 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн 11:00 цагт танхим болон эчнээ хосолсон хэлбэрээр зохион байгуулагдана.

### Санамж:

- ✓ Та зөвхөн өөрийн дэмжиж буй саналын урд байгаа  сонголтыг  тэмдэглэгээгээр тэмдэглэснээр саналаа өгөхийг анхаарна уу.

Д/д	Шийдвэрлэх асуудал	Зөвшөөрсөн	Татгалзсан	Түдгэлзсэн
1.	Компанийн 2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг баглана	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
2.	Компани нэмж хувьцаа гаргах, нэмж гаргаж буй хувьцааг тэргүүн ээлжинд худалдан авах эрхийг хэрэгжүүлэх эсэхийг шийдвэрлэх	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
3.	Бусад	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>

Хувьцаа эзэмшигчийн гарын үсэг, тайлал \_\_\_\_\_ / \_\_\_\_\_

Бүртгэсэн (үнэт цаасны компани) \_\_\_\_\_

Саналын хуудсыг хүлээн авсан эрх бүхий этгээдийн гарын үсэг, тайлал:

\_\_\_\_\_ / \_\_\_\_\_

2024 оны ..... сарын ..... -ны өдөр

### САНАЛЫН ХУУДСЫГ АШИГЛАХ САНАМЖ:

Тайлбар / Санамж:

- Та саналын хуудсыг бөглөхдөө өөрийн сонгож буй хэсэгт (✓),  эсхүл бусад тэмдэглэгээг тэмдэглэнэ үү. Таны санал шийдвэрлэх асуудал бүрээр бүртгэлийн өдрөөр эзэмшиж буй хувьцааны тоогоор үржигдэж тооцогдоно.
- Та саналаа урьдчилан заасан хугацаанд брокер, дилерийн компаниар дамжуулан эсхүл Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 2-р хороо, Соёмбо тауэр, 21 давхар, 211 тоот Компанийн байранд саналын хуудсаар саналаа өгнө.

3. Хэрэв өөр хүнээр төлөөлүүлэн саналаа өгөх бол төлөөлөх хүн Монгол Улсын хууль тогтоомжид нийцсэн итгэмжлэлийг авчран саналын хамт өгсөн тохиолдолд таны санал хүчинтэйд тооцогдоно.
4. Засварласан, балласан, тэмдэглэгээг буруу үйлдсэн бол саналын хуудас хүчингүйд тооцогдоно.

.....

Энэ хэсгийг санал хураалтын тооллогын комисс бөглөнө.

Саналын хуудсыг хүчинтэйд тооцон тоолсон эсэх (доогуур зурах): Тийм / Үгүй

Тооллогын комиссын даргын гарын үсэг, тайлал: \_\_\_\_\_ / \_\_\_\_\_

Саналын хуудсыг хүчингүйд тооцсон үндэслэл: \_\_\_\_\_

---

---

УЛААНБААТАР ХОТ  
“Глобал Монголиа Холдингс” ХК  
Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны  
03 дугаар сарын 15-ны өдрийн 24-06  
тоот тогтоолын Хавсралт №4


ХОЛДИНГС  
ХК

ТТБ5207.а.2015293

### Хувьцаа эзэмшигчдийн танилцаж болох баримт бичгийн жагсаалт

- ✓ “Глобал Монголиа Холдингс” ХК-ийн 2023 оны жилийн үйл ажиллагааны тайлан;
- ✓ “Глобал Монголиа Холдингс” ХК-ийн 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан;
- ✓ “Глобал Монголиа Холдингс” ХК-ийн 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг баталгаажуулсан аудитын дүгнэлт;
- ✓ “Глобал Монголиа Холдингс” ХК-ийн хувьцааны сүүлийн 6 сарын болон сүүлийн 30 хоногийн арилжааны жигнэсэн дундаж ханшийн мэдээлэл;
- ✓ Ногдол ашиг хуваарилах эсэх тухай ТУЗ-ийн хурлын 2024 оны 02 дугаар сарын 19-ний өдрийн 24/01 тоот тогтоол;
- ✓ Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцэх асуудалд санал өгөх Саналын хуудасны загварууд;
- ✓ Бусад





Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас гарах тогтоолын төсөл (1)

**“ГЛОБАЛ МОНГОЛИА ХОЛДИНГС” ХК-ИЙН  
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ  
/төсөл/**

2024 оны 04 сарын 25-ны өдөр

Дугаар .....

Улаанбаатар хот

**Компанийн 2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн  
удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг батлах тухай**

Компанийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.11 дэх хэсэг, 62 дугаар зүйлийн 62.1.9 дэх заалт, 96 дугаар зүйлийн 96.5 дахь хэсэг, “Глобал Монголиа Холдингс” ХК /цаашид “Компани” гэх/-ийн дүрмийн холбогдох хэсгийг тус тус үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийн дагуу энэхүү тогтоолын Хавсралт №1-т заасны дагуу Компанийн 2023 оны үйл ажиллагааны тайланг, Хавсралт №2-т заасны дагуу Компанийн 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг баталсугай.
2. Компанийн 2023 оны үйл ажиллагааны тайлан болон 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг, аудитын дүгнэлтийн хамт тус тус Санхүүгийн зохицуулах хороо, Хөрөнгийн биржид хүргүүлэх ажлыг Гүйцэтгэх захирал /Бэк Квангюэл /-д үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА: \_\_\_\_\_ /КИМ КИ ХЮУН /

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас гарах тогтоолын төсөл (2)

**“ГЛОБАЛ МОНГОЛИА ХОЛДИНГС” ХК-ИЙН  
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ  
/төсөл/**

2024 оны 04 сарын 25-ны өдөр

Дугаар .....

Улаанбаатар хот

**Компани нэмж хувьцаа гаргах, нэмж гаргаж буй хувьцааг тэргүүн ээлжинд худалдан авах эрхийг хэрэгжүүлэх эсэхийг шийдвэрлэх, дүрмийн шинэчилсэн найруулга батлах тухай**

Монгол Улсын “Компанийн тухай хууль”-ийн 17 дугаар зүйл, 31 дүгээр зүйлийн 31.2.2 дахь заалт, 38, 53, 54 дүгээр зүйл, 62 дугаар зүйлийн 62.1.1, 62.1.3, 62.1.8, 62.1.10-62.1.11 дэх заалт, 87-93 дугаар зүйл, 2024 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн тооллогын комиссын ..... дугаар тогтоол, “Глобал Монголиа Холдингс” ХК /цаашид “Компани” гэх/-ийн дүрмийн холбогдох хэсгийг тус тус үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Компанийн зарласан энгийн хувьцааны тоо \_\_\_\_\_ ( \_\_\_\_\_ ) ширхэг, гаргасан энгийн хувьцааны тоо \_\_\_\_\_ ( \_\_\_\_\_ ) ширхэг, зарласан боловч гаргаагүй хувьцааны тоо \_\_\_\_\_ ( \_\_\_\_\_ ) ширхэг болохыг дурьдсугай.
2. Компанийн зарласан хувьцаанаас \_\_\_\_\_ ( \_\_\_\_\_ ) ширхэг энгийн хувьцааг стратегийн хөрөнгө оруулагч нарт санал болгон хаалттай хүрээнд арилжаалахаар нэмж гаргасугай.
3. Нэмж гаргах хувьцааны хаалттай хүрээнд санал болгох үнийг тогтоох бүрэн эрхийг Төлөөлөн удирдах зөвлөл (Ким Ки Хюун)-д олгосугай.
4. Компанийн зарласан хувьцааны хүрээнд нэмж хувьцаа гаргахтай холбоотой ажлыг хариуцан зохион байгуулах бүрэн эрхийг Төлөөлөн удирдах зөвлөлд олгосугай.
5. Нэмж хувьцаа гаргах гэж байгаатай холбоотойгоор одоогийн хувьцаа эзэмшигчдэд тэргүүн ээлжид хувьцаа худалдан авах эрхийг эдлүүлэхээр шийдвэрлэсүгэй.
6. Хаалттай хүрээнд хувьцаа нэмж гаргахтай холбоотой шийдвэрийн биелэлтийг хангаж ажиллах, Санхүүгийн зохицуулах хороо, “Монголын хөрөнгийн бирж” ХК-д хувьцаагаа бүртгүүлэхэд шаардлагатай бүх талын зохион байгуулалтын арга хэмжээг авч ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлд даалгаж, холбогдох гэрээ хэлцэл байгуулах баримт бичгүүдэд гарын үсэг зурах бүрэн эрхийг Төлөөлөн удирдах зөвлөл (Ким Ки Хюун)-д олгосугай.
7. Компани нэмж хувьцаа гаргасантай холбогдуулан Компанийн дүрмийн шинэчилсэн найруулгыг энэхүү тогтоолын Хавсралт №1-т заасны дагуу баталсугай.
8. Компанийн дүрмийн шинэчилсэн найруулга болон Хувьцаа эзэмшигчдийн хурлаас гарсан тогтоолыг Санхүүгийн зохицуулах хороо, Монголын Хөрөнгийн Биржид хууль, журамд заасан хугацаанд хүргүүлэх, холбогдох зөвшөөрлийг авах, холбогдох зөвшөөрлийг авсны дараа улсын бүртгэлд бүртгүүлэх ажлыг хариуцан зохион байгуулахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга Ким Ки Хюунд үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА: \_\_\_\_\_ /КИМ КИ ХЮУН /



Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас гарах тогтоолын төсөл (3)

**“ГЛОБАЛ МОНГОЛИА ХОЛДИНГС” ХК-ИЙН  
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ  
/төсөл/**

2024 оны 04 сарын 25-ны өдөр

Дугаар .....

Улаанбаатар хот

**Шаардах эрх хэрэгжүүлэх тухай**

Компанийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2 дахь хэсэг, 53, 54 дүгээр зүйл, “Глобал Монголиа Холдингс” ХК (цаашид “Компани” гэх)-ийн дүрмийн холбогдох хэсгийг тус тус үндэслэн, Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас **ТОГТООХ НЬ:**

1. Компанийн дүрмийн шинэчилсэн найруулга батлагдаж буйтай холбогдуулан 2024 оны 04 дүгээр сарын 25-ны өдөр хуралдсан хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцоогүй, оролцсон ч эсрэг саналтай байсан хувьцаа эзэмшигчид нь компанид хувьцаагаа эргүүлэн худалдахыг шаардах эрхтэй болохыг дурьдсугай.
2. Нэмж хувьцаа гаргахыг Санхүүгийн зохицуулах хороо болон Монголын Хөрөнгийн Биржээс тус тус зөвшөөрсний дараа шаардах эрхийн хүрээнд нэгж хувьцааг нэг бүрийг \_\_\_\_\_ ( \_\_\_\_\_ ) төгрөгөөр худалдаж авахыг зөвшөөрсүгэй.
3. Компанид хувьцаагаа эргүүлэн худалдахаар хүсэлт захиалгаа ирүүлсэн хувьцаа эзэмшигчдийн хувьцааг худалдан авах үүргийг Компанийн тухай хуулийн 53 дугаар зүйлийн 53.3-т заасны дагуу хяналтын багцын хувьцаа эзэмшигчдэд зөвшөөрсүгэй.

ХУРЛЫН ДАРГА: \_\_\_\_\_ /КИМ КИ ХЮУН /